



202

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2009 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэнд тэтгэвэр олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг аймаг /нийслэл/-ийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн дарга нарт даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга Ж.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.



ДАРГА

Ч.АЛТАНХУЯГ

103  
Нийгмийн даатгалын ерөнхий газрын  
даргын 2009 оны 12 дугаар сарын 23-ны  
өдрийн 408 тоот тушаалын хавсралт.

## ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ТЭТГЭВЭР ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудад заасан болзол, нөхцөлийн дагуу тэтгэвэр тогтоолгосны дараа гадаадад удаан хугацаа (6 сараас дээш)-гаар болон байнга оршин суухаар явсан Монгол Улсын иргэн, тэтгэвэр авагч (Цаашид “гадаадад оршин суугаа тэтгэвэр авагч” гэнэ)-д тэтгэвэр олгоход энэхүү журмыг баримтална.

### Хоёр. Тэтгэвэр олгох журам

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу тэтгэвэр тогтоолгосны дараа гадаадад удаан хугацаа (6 сар ба түүнээс дээш)-гаар болон байнга оршин суухаар шилжин явсаны улмаас өөрийн биеэр тэтгэврээ сар бүр авах боломжгүй үед түүний хууль ёсны итгэмжлэгдсэн эхнэр, нөхөр, хамаатан садан, шүүхээр тогтоосон асран хамгаалагч (Цаашид “итгэмжлэгдсэн хүн” гэнэ.)-д тэтгэврийг нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсгүүд, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан итгэмжлэлээр олгоно.

2.2. Гадаадад оршин суугаа тэтгэвэр авагчийн Монгол Улсад оршин суудаг газрын харъяа аймаг, сум, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, тасаг, байцаагч (Цаашид “нийгмийн даатгалын байгууллага” гэнэ)-д бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн түүний тэтгэврийг итгэмжлэгдсэн хүнд нь олгох зөвшөөрөл (итгэмжлэл) олгоно.

2.3. Итгэмжлэлээр тэтгэвэр авдаг гадаадад оршин суугаа тэтгэвэр авагч нь Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт хаягийн бүртгэл хийлгэсэн байх шаардлагатай бөгөөд эдгээр газруудаас тухайн оронд оршин сууж байгаа тухай тодорхойлолт (мэдэгдэл)-ыг жил бүр гаргуулан авч дараа оны 1 дүгээр сард багтаан нийгмийн даатгалын байгууллагад албан ёсоор ирүүлсэн байна.

2.4. Тэтгэвэр авагчийн амьдарч байгаа улсад Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар байхгүй тохиолдолд тухайн улсын Засаг, захиргааны байгууллагаас уг улсад оршин сууж байгаа тухай тодорхойлолт (мэдэгдэл)-ыг авч энэ журмын 2.3-т заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

2.5. Нийгмийн даатгалын байгууллага нь энэхүү журмын 2.3, 2.4-т заасан холбогдох газраас ирүүлсэн тодорхойлолт (мэдэгдэл)-ыг гадаадад оршин суугаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргаж, түүний хууль ёсны итгэмжлэгдсэн хүнд тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгох асуудлыг шийдвэрлэнэ.

2.6. Нийгмийн даатгалын байгууллага нь гадаадад оршин суугаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг энэхүү журмын 2.3, 2.4-т заасан холбогдох газраас ирүүлсэн тодорхойлолт (мэдэгдэл)-ыг үндэслэн өөрийнх нь хүсэлтээр банкин дахь харилцах данс болон хадгаламжид нь сар бүр шилжүүлэн олгож болно.

2.7. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 2.3, 2.4-т заасан тодорхойлолт (мэдэгдэл)-ыг мөн журмын 2.3-т заасан хугацаанд ирүүлээгүй тэтгэвэр авагчийн тэтгэврийг тодорхойлолт (мэдэгдэл)-оо ирүүлэх хүртэл хугацаанд түр түдгэлзүүлэн зогсоож, түүний итгэмжлэгдсэн хүнд тэтгэврийг олгохгүй.

2.8. Гадаадад оршин суугаа тэтгэвэр авагч хүндэтгэх шалтгаангүйгээр 1 жил ба түүнээс дээш хугацаанд энэ журмын 2.3, 2.4-т заасан тодорхойлолт (мэдэгдэл)-ыг ирүүлээгүй бол өөрийн биеэр ирж тэтгэврээ авах хүртэл хугацаанд тэтгэврийг нь зогсооно.

2.9. Гадаадад оршин суугаа тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч энэ журмын 2.3, 2.4-т заасны дагуу тодорхойлолт (мэдэгдэл)-оос гадна тахир дутуугийн тэтгэвэр авагч бол Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа тогтоосон тухай акт, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч бол хүүхдийн суралцаж буй сургуулийн тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн нөхцөлд түүний итгэмжлэгдсэн хүнд болон асран хамгаалагчид тэтгэврийг нь олгоно.

2.10. Энэ журмын 2.9-д заасан тахир дутуугийн тэтгэвэр авагч өөрийн биеэр Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хуралд оролцож, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь, хугацаагаа тогтоолгосон байна.

2.11. Гадаадад оршин суугаа тэтгэвэр авагч нас барсан бол энэ талаар түүний тэтгэврийг авч байсан итгэмжлэгдсэн хүн нь нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ журмын 2.3, 2.4-т заасны дагуу ирүүлсэн тодорхойлолт (мэдэгдэл)-ыг үндэслэн түүний ар гэрт нас барсны дараагийн сарын тэтгэвэр болон оршуулгын тэтгэмжийг олгоно.

**Гурав. Журмын хэрэгжилтэд тавих хяналт,  
хүлээлгэх хариуцлага**

3.1. Энэ журмын дагуу гадаадад оршин суугаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтын байдалд нийгмийн даатгалын байгууллага хяналт тавина.

3.2. Гадаадад оршин суугаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн илүү авсан болон олгосон тэтгэврийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлж, торгох болон хуульд заасан бусад хариуцлага хүлээлгэнэ.

----- оОо -----